

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ

Я.АРИУНБОЛД

ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа

Товч агуулга: Команд штабын сургууль /КШС/-ийн онолын үндэс, КШС-ийн тодорхойлолт, онол, арга зүйн ялгааг эх сурвалжуудаас судлан судлаачийн зүгээс санал дэвшүүлсэн.

Түлхүүр үгс: Команд штабын сургууль /КШС/, цэргийн сургалт, удирдах бүрэлдэхүүний сургалт.

Оршил

Монгол Улсын төрийн цэргийн байгууллын удирдлага нь улс төрийн, төрийн захиргааны, цэргийн мэргэжлийн удирдлагаас бүрдэнэ хэмээн батлан хамгаалах тухай хуулинд тодорхойлсон бөгөөд цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллага болох штабын сургалт бэлтгэлийн дээд хэлбэр болсон Команд штабын сургуулийн онол, арга зүйн талаар онолын судалгаа хийж, санал дүгнэлтийг дэвшүүллээ.

Нэг. Команд штабын сургуулийн онол

Команд штабын сургууль (КШС)-ийг зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд зохион байгуулан явуулдаг хэдий ч тодорхойлолтын хувьд нэгдсэн ойлголтонд хүрч томъёологдоогүй өөрсдийн нэр

томъёоны тайлбар толь, тушаал журам, зааварт тусгасан байдаг.

Тухайлбал: 2003 оны “Монгол Улсын хилчний тайлбар толь”¹, 2010 оны “Хилийн нэр томъёоны тайлбар толь”², 2014 оны “Цэргийн нэр томъёоны тайлбар толь”³, 2017 оны “Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь”⁴, Онцгой байдлын ернхий газрын даргын 2017 оны 12 сарын 20-ны дрийн А/323 дугаар тушаалаар батлагдсан “Гамшигаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”⁵, Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2022 оны 11 сарын 30-ны А/658 дугаар тушаалаар батлагдсан “Багшийн багц цагаар үнэлэх журам”⁶ -уудад тус тус тодорхойлсон байна. КШС-ийн онолын үндэс нь цэргийн сургалтад тулгуурлагдана. Цэргийн сургалт нь алба хаагч нэг бүрийг гүйцэтгэх үүрэгт нь сургах⁷ тогтолцоот шинж чанартай зорилго, агуулга, арга, хэлбэр, технологитой

¹ Сүндэв, П. (2003). “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Монгол Улсын хилчний тайлбар толь, (198), Улаанбаатар хот

² Ганболд, М. (2010). “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Хилийн нэр томъёоны тайлбар толь, (122), Улаанбаатар хот

³ Паламдорж, Ш., Дашзэвэг, Ц. (2014). “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Цэргийн нэр томъёоны тайлбар толь, (180), Улаанбаатар хот

⁴ Жавхланцогт, В., Муратхан, А., (2017). “Команд штабын сургууль”-ийн тайлбар.

Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь, (75), Улаанбаатар хот⁵. Гамшигаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар, 2017, А/323 дугаар тушаал⁶ Багшийн багц цагаар үнэлэх журам, 2022, А/658 дугаар тушаал

⁷ Сүхбат, Р. (2016), Цэргийн сургалтын тогтолцоо. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. УБ. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 13

төлөвлөгөөт үйл ажиллагаа ¹. Цэргийн сургалтын тогтолцоо нь албан ба албан бус сургалтын нэгдэл байх ба мэрэгжил эзэмшүүлэх, мэрэгшүүлэх, жигдрэлтийг хангах, хөгжүүлэх гэсэн төрлүүдтэй, бүтэцээр нь хүн нэг бүрийн бэлтгэл, анги салбарын бэлтгэл, штабын бэлтгэл, үечлэлээр нь нэгдүгээр үеийн буюу өвлийн, хоёрдугаар үеийн буюу зуны, хамрах хүрээгээр нь офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагч, энгийн ажилчдын, зориулалтаар нь албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл² гэж ангилагдана. Цэргийн сургалт нь боловсрол олгох сургалтаас цэргийн мэргэжил эзэмшүүлэх, мэрэгшүүлэх, ур чадвар олгох, дадлагжуулах, жигдрэлтийг хангах зорилгоор тактикийн бэлтгэл сургалтын төвшинг илэрхийлдэг тоон болон чанарын үзүүлэлт, нормативыг өөртөө багтаасан 25 хувь нь онолын 75 хувь нь практик үйл ажиллагаа байдаг онцлогтой³.

Цэргийн сургалтын хэлбэрүүдийг цэргийн сургалтын бүтэцэд хүн нэг бүрийн бэлтгэл, салбарын бэлтгэл, штабын бэлтгэл гэж төрөлжүүлэн, хүн нэг бүрийн бэлтгэлд: Лекц, семинар, бие даалт, бүлгийн дасгал, шуурхай дадлага, салбарын бэлтгэлд: Тактик жагсаалын хичээл, тактикийн хичээл, сурган зааварлах хичээл, тактикийн хээрийн сургууль, байлдааны буудлагатай такийн хээрийн сургууль, штабын бэлтгэлд: Штабын

хэсэгчилсэн дадлага, штабын нэгдсэн дадлага, КШС, цэргийн тоглоом гэсэн хэлбэрүүд хамаарна⁴ хэмээн тодорхой эх сурвалжууд, тусгасан байна. КШС-ийн зорилго нь суралцагч штабуудын үүрэг гүйцэтгэх бэлтгэлийн түвшинг “сайжруулах”, “нэмэгдүүлэх”, “төгөлдөржүүлэх”, “жигдрүүлэх”, “дадлагажуулах”, “өндөржүүлэх”, “эзэмшүүлэх”, “шалгах”, “судлах” гэсэн санааг тусгасан, сургуульд оролцож байгаа анги, салбар тус бүрт тохирсон байх ба зориулалтаар нь төлөвлөгөөт, шалгалтын, үзүүлэх, туршилт шинжилгээний гэж ангилж, оролцож байгаа штабын бүрэлдэхүүнээс хамаарч нэг болон хоёр шатны⁵, сургуулийн сэдэв, боловсруулах асуудлаас хамааран сургуулийн түвшин, үе шатууд болон нэг болон хоёр талын сургууль⁶ болох нь тодорхойлогдоно⁷.

Хоёр: Команд штабын сургуулийг явуулах арга зүй

КШС нь сургагч буюу удирдлагын бүлэг, суралцагч буюу сургуульд оролцож буй суралцагч штабын үйл ажиллагааны нэгдэл байх бөгөөд сургуулийг зохион байгуулах арга зүй нь сургуулийн бэлтгэл хангах, сургуулийг удирдан явуулах, дүн гаргах ажиллагаа байна. КШС-ийн бэлтгэл хангах, удирдан явуулах, дүн гаргах ажлыг хариуцах удирдлагын бүлэг томилогдож⁸, сургуулийг байнгийн байрлал болон газар орон дээр байр зүйн зураг, план

¹ Мягмаржав, Г. Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс (1998). УБ. (х.27).

² Бадамбазар, Ж., Соронзонболд, Т. (2016), Офицерын бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн тогтолцоо түүнийг боловсронгуй болгох нь. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. Улаанбаатар. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 33

³ ХХБ, “Сургалт бэлтгэл - 2012” хөтөлбөр (2009), УБ.

⁴ ЗХЖШ. (2016). Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журамын 1.8-р заалт

⁵ Ганболд, Ц., Баатар, Д. (2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х12.

⁶ Гомбогарав, Д. (2001). Нэгтгэл ангиудад байлдааны бэлтгэл сургалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штабын ажил. Фонын лекц. УБХИС. УБ. 57-р тал

⁷ Жаргалан, П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ.

⁸ Жаргалан, П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ.

зураг, бүдүүвч төвлөгөөг ашиглан зохион байгуулна ¹. Удирдлагын бүлэгт сургуулийн удирдагч, орлогч, туслах, удирдлагын штаб, чиглүүлэгч, дундын хянагчид багтана².

КШС-ийг бэлтгэх ажилд дараах асуудлууд орно. Үүнд:

1. Сургуулийн анхны өгөгдөхүүнийг тодорхойлох, тодотгох;

2. Сургуулийн удирдлагын баримт бичиг боловсруулах;

3. Сургуулийг удирдах офицерууд, төрөл мэргэжлийн цэргийн дарга нарыг бэлтгэх;

5. Сургуульд оролцох анги, салбар, захирагч, штабыг бэлтгэх;

4. Сургууль явуулах байр /газар орон/-ыг бэлтгэх;

6. Сургуульд шаардагдах хангалтыг зохион байгуулах асуудал багтана³.

Сургуулийн анхны өгөгдөхүүн тодорхойлогдсоноор сургуулийн удирдлагын үндсэн баримт бичиг болох сургуулийн бодлого төлөвлөгөөг зурмал болон бичмэл байдлаар боловсруулж, зохион байгуулалтын, сургалт арга зүйн, оперативын, лавлагаа тайлан мэдээллийн зэрэг удирдлагын баримт бичгүүд боловсруулагдана.

Бэлтгэл ажил хангагдсанаар оператив удирдамж, тактикийн даалгавар, АББ-ын дохио өгч хийсвэр цаг зарлаж сургуулийг эхлүүлнэ⁴.

Сургуулийг тасралтгүй, ойлгомжтой явуулахын тулд сургуулийн удирдлагын штабаас суралцагч нараас мэдээ ирүүлэх журам, цагийг тогтоож мөн суралцагчдад зайлшгүй шаардлагтай

нэмэгдэл мэдээллийг дундын хянагч, чиглүүлэгч нараар дамжуулан цаг хугацаанд нь хүргэж ⁵ сургуулийг шатлан хөгжүүлэх байдлаар удирдан явуулна.

КШС-ийн дүн гаргах ажиллагаа нь сургуулийг удирдан явуулах ажлын нэг хэсэг байх бөгөөд удирдлагийн бүлгээс сургуулийн үе, шат бүрт суралцагчзахирагч, штабын албан тушаалтан нэг бүрийн хийж гүйцэтгэсэн ажлын явц байдалтай танилцах явцын буюу хэсэгчилсэн сургуулийн төгсгөлд сургуульд оролцсон бүрэлдэхүүн нэг бүрийн болон штабуудыг дүгнэх нэгдсэн арга хэмжээнээс бүрдэнэ⁶.

Суралцагч захирагч, штабын ажлыг үнэлэхдээ онолын мэдлэг, цагийн байдлыг үнэлж, шийдвэр гарган салбар нэгжүүддээ цаг тухайд нь үүрэг хүргэж, тасралтгүй, удирдах чадварыг эзэмшсэн байдал, төрөл мэргэжлийн албадын дарга нарын гар нийлэмжтэй ажиллагаа, боловсруулж буй баримт бичиг цаг үеэ олсон, цагийн байдлыг бүрэн тусгасан, штабын соёл, бүх төрлийн хангалт, харилцан ажиллагааг хэрхэн зохион байгуулж байгаад үнэлэлт өгнө⁷.

Сургуулийн явцад ахлах дундын хянагч, дундын хянагч нараас дүнгийн хүснэгт, тэмдэглэл, саналыг авч нэгтгэн удирдлагын штабт тогтоосон цагт танилцуулна. Сургуулийн удирдагч, удирдлагын штаб, суралцагч захирагч штабын шийдвэрийг зурмал, бичмэл, бүдүүвч, график, фото, дүрс бичлэг зэрэг нотлох баримтуудад тулгуурлан хийх илтгэлийг сонсож,

¹ Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 139.

² Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х15.

³ ЗХЖШ.(2016). Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам

⁴ Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х16

⁵ Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 140.

⁶ Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 141.

⁷ Жаргалан.П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ.

сургуулийн бодлого төлөвлөгөөтэй харьцуулан үнэлж дүн гаргана¹.

Суралцагч захирагч штаб гаргасан шийдвэр, боловсруулсан баримт бичгүүдээ, сургуулийн бодлого төлөвлөгөөтэй харьцуулан өөрсдийнхөө алдаа, дутагдалд дүн шинжилгээ хийх боломжыг удирдлагын бүлгээс олгоно.

Дүн гаргах ажиллагаа нь сургууль явуулах шийдвэр гарсан цагаас хойш зэрэгцээ явагдаж сургуулийн бэлтгэл хангасан байдал, сургуулийн хэсэгчилсэн болон нэгдсэн дүнг хүн нэг бүр дээр болон суралцагч штаб бүрээр гаргана².

Суралцагч штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дүнг гаргах ажлын үндсийг захирагчийн шийдвэр, түүний биелэлтийг задлан шинжлэх ажиллагаа бүрдүүлнэ.

Удирдлагын бүлэгээс нэгдсэн дүн гаргахдаа суралцагч штабын дутагдлыг тоочилгүй тухайн цагийн байдалд ямар шийдвэр гарган яаж ажиллавал ашигтай байсныг хууль, эрх зүй, төрөөс баримтлах бодлого, дүрэм, журам, заавар, норматив, онолын үндэслэлээр нотолж, тайлбарлаж өгнө³.

Хэсэгчилсэн дүнгийн нэгтгэл нь тухайн суралцагч штабын нэгдсэн дүн байх бөгөөд КШС-ийн нэгдсэн дүнг удирдлагын штабын дарга, сургуулийн сэдэв, боловсруулах асуудлууд, анхны цагийн байдал, сургуулийн бэлтгэл хангагдсан байдал сургуулийн явц дахь удирдлагын штаб, суралцагч штабуудын хийж гүйцэтгэсэн ажлын талаар дүгнэсэн нэгдсэн илтгэлийг танилцуулна. Сургуулийн удирдагч штабын даргын илтгэлтэй танилцаж, сургуулийн зорилго, үр дүнг товч дурьдаад, сургуулийн удирдлагын

штаб, суралцагч штабуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, жигдрэлт зэрэгт ерөнхий үнэлэлт өгч, цаашид анхаарах асуудал, илэрсэн дутагдлыг арилгахад ямар арга хэмжээг хэдий хугацаанд авч хэрэгжүүлэхийг заан дээд шатны ахлах даргад танилцуулах илтгэлийн төсөл, сургуулийн холбогдох материал, нэгдсэн дүнгийн нотломж зэргийг бэлэн болгох хугацааг зарлаж, сургуулийн хаалтын ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зааварчилгаа өгнө. Сургуулийн нэгдсэн дүн гарснаар сургуульд оролцсон бүрэлдэхүүн сургуулийн төгсгөлийн үеийн холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн заасан цагт хаалтын ажиллагаанд тусгай хөтөлбөрийн дагуу оролцоно⁴.

Сургуулийн удирдагчийн ахлах даргад илтгэх сургуулийн дүнгийн илтгэлд сургуулийн зорилгын биелэлтийн байдал, зарцуулсан материал, хэрэгслийн хэмжээ, КШС-д оролцсон анги, байгууллагын захирагч, штабын сургуулийн бэлтгэл болон явцад илэрсэн гол дутагдал, ажиглагдсан тэргүүн туршлага, тэдгээрт өгсөн үнэлэлт, дүгнэлт, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаархи санал зэргийг тусгана.

Дүгнэлт, санал

Команд штабын сургууль (КШС)-ийг зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд зохион байгуулан явуулдаг хэдийч онол арга зүйн талаар тусгасан ном, эх сурвалж хомс нэр томьёо тодорхойлолтын хувьд байгууллагууд өөр өөрсдийн

¹ Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 142.

² Ганболд.Ц., Баатар.Д.(2013). Штабын сургалт бэлтгэл УБ., х18.

³ Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 142.

⁴ Лхагважав.Д., Бямбацогт.Б.(1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ.,х 142.

нэр томъёоны тайлбар толь, тушаал журам, зааварт тусган ашиглаж байгаа зэргээс судлаачийн зүгээс дараах санал дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

1. КШС нь захирагч, штаб удирдах бүрэлдэхүүнийг гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах, үүссэн цагийн байдалд шийдвэр гаргах чадвар олгох, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг нь нэмэгдүүлэх зорилгоор байр зүйн зураг ашиглан танхимд болон газар орон дээр явагдах цэргийн сургалтын хэлбэрийг хэмээн тодорхойлж болох юм.

2. КШС-ийн онол нь цэргийн сургалтын онолд тулгуурлагдаж арга зүй нь КШС-ийг бэлтгэх, явуулах, дүн гаргах гэсэн хэсгээс бүрдэж, сургагч буюу удирдлагын бүлэг, суралцагч захирагч, штабын үйл ажиллагааны нэгдэлийн цогц хэмээн дүгнэж болохоор байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, 2016, 9.1
- ХХБ. “Сургалт бэлтгэл – 2012” хөтөлбөр. (2009). УБ.
- ЗХЖШ. “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам”. (2016).
- Багшийн багц цагаар үнэлэх журам, 2022, А/658 дугаар тушаал
- Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар, 2017, А/323 дугаар тушаал
- Сүндэв, П. (2003). “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Монгол Улсын хилчний тайлбар толь, (198), Улаанбаатар хот
- Ганболд, М. (2010) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар.

Хилийн нэр томъёоны тайлбар толь, (122), Улаанбаатар хот

- Паламдорж, Ш., Дашзэвэг, Ц. (2014) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Цэргийн нэр томъёоны тайлбар толь, (180), Улаанбаатар хот

- Жавхланцогт, В., Муратхан, А., (2017) . “Команд штабын сургууль”-ийн тайлбар. Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь, (75), Улаанбаатар хот

- Лхагважав, Д., Бямбацогт, Б. (1974). Офицер, захирагч, штабууд, нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ., 139-р тал

- Ганболд, Ц., Баатар, Д. (2013). Штабын сургалт бэлтгэл УБ., 12-р тал

- Мягмаржав, Г. Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс (1998). УБ. (х.27).

- Сүхбат, Р. (2016), Цэргийн сургалтын тогтолцоо. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 13

- Бадамбазар, Ж., Соронзонболд, Т. (2016), Офицерын бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн тогтолцоо түүнийг боловсронгуй болгох нь. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. УБ. БХИС. Эрдэм шинжилгээний хуралын эмхтгэл, х 33

- Гомбогарав, Д. (2001). Нэгтгэл ангиудад байлдааны бэлтгэл сургалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штабын ажил. Фонын лекц. УБХИС. УБ. Х 57

- Жаргалан, П. (2007). КШС-ийг төлөвлөн зохион байгуулж явуулах штабын ажил. Фондын лекц. УБ. Х3